



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнхэр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/127/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх
аудитор: Т.Байгалмаа
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Алтанчимэг
Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Албан шаардлага	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1.Аудитын санал дүгнэлт

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс: 976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn	ЦЭНХЭР СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА Э.БОЛОРЦЭЦЭГ ТАНАА
2022.02.23 № 58	
танай _____ -ны № _____ -т	
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	
Хязгаарлалттай дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнхэр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цэнхэр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгуулагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<p>Цэнхэр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар Байгаль орчны улсын байцаагчийг өндөр насны тэтгэвэрээ тогтоолгоогүй байхад төрийн албанд ажилласан 36 сарын тэтгэмж олгосон, Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах саналыг Төрийн албан салбар зөвлөлд хүргүүлээгүй, түүнд олгох цалин хөлс, нэмэгдлүүдийг хуучин хэвээр олгосон зэрэг зөрчил илэрсэн.</p>	
<p>Эдгээр зөрчил нь Төрийн албаны тухай хуулийн 27.2, 60.1, "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 1.1, 5.3 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p>	

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>47,938,910.00</u>	<u>46,021,185.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	38,438,910.00	32,621,185.00
351	Түүхий эд материал	28,224,025.00	28,810,600.00
35110	Тусгай зориулалттай материал	23,224,025.00	17,418,920.00
35130	Эм боох материал	5,000,000.00	11,391,680.00
354	Хангамжийн материал	10,214,885.00	3,810,585.00
35410	Бичиг хэргийн материал	1,634,805.00	869,405.00
35420	Аж ахуйн материал	4,321,800.00	1,661,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	96,500.00	11,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,600,900.00	42,000.00
35450	Барилгын засварын материал	710,880.00	425,880.00
35470	Бусад хангамжийн материал	1,850,000.00	-
36	НӨӨЦИЙН БАРАА	9,500,000.00	13,400,000.00
36300	Тэжээлийн нөөц	9,500,000.00	13,400,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,900,127,933.95</u>	<u>1,926,469,246.33</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,900,127,933.95	1,926,469,246.33
392	Биет хөрөнгө	1,644,517,933.95	1,670,209,246.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	955,690,247.00	1,015,681,516.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(200,088,188.92)	(232,218,053.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	237,454,800.00	237,454,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(108,190,178.02)	(127,464,644.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	177,708,293.86	202,015,363.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(94,035,119.26)	(109,165,431.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,485,650.00	65,772,818.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,727,891.94)	(48,822,217.91)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	8,500,000.00	8,500,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	975,884,146.00	1,051,667,744.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(332,163,824.77)	(403,112,646.87)
393	Биет бус хөрөнгө	255,610,000.00	256,260,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	255,610,000.00	255,610,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,948,066,843.95</u>	<u>1,972,490,431.33</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,761,811.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,761,811.00	-
413	Өглөг	2,761,811.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,761,811.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,945,305,032.95</u>	<u>1,972,490,431.33</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,945,305,032.95	1,972,490,431.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	650,717,567.00	650,717,567.00
51101	Өмч: - төрийн	650,717,567.00	650,717,567.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,023,277,154.45	1,050,462,552.83
51210	Өмнөх үеийн үр дүн	1,023,277,154.45	1,023,277,154.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	271,310,311.50	271,310,311.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,948,066,843.95</u>	<u>1,972,490,431.33</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	553,338,163.00	1,016,442,205.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	111,819,425.00	81,807,239.59
120	Нийтлэг татварын бус орлого	111,819,425.00	81,807,239.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	111,819,425.00	81,807,239.59
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,669,700.00	1,867,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	110,149,725.00	79,939,639.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,518,738.00	934,634,966.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,730,838.00	36,085,266.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,150,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,730,838.00	21,435,266.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	420,787,900.00	898,549,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	420,787,900.00	898,549,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	612,938,047.16	989,256,807.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	612,938,047.16	726,030,407.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	592,614,468.32	628,474,086.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,888,049.16	259,315,900.00
210101	Үндсэн цалин	254,888,049.16	259,315,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,850,011.00	34,007,990.64
210201	Тэтгэврийн даатгал	25,042,411.00	23,635,390.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,558,600.00	2,593,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,046,900.00	2,074,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	511,700.00	518,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,690,400.00	5,186,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,666,512.00	15,200,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,774,305.00	6,000,000.00
210302	Түлш, халаалт	15,887,207.00	9,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,301,184.00	54,386,383.00
210401	Бичиг хэрэг	4,840,950.00	5,765,400.00
210402	Тээвэр, шатахуун	20,166,470.00	23,969,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	3,223,400.00
210404	Ном, хэвлэл	480,000.00	464,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,584,754.00	5,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,229,010.00	15,159,933.00
210408	Бараа материал акалсны зардал	-	803,500.00
2105	Нормативт зардал	-	1,258,800.00
210502	Хоол, хүнс	-	1,258,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	207,000.00	842,000.00
210604	Урсгал засвар	98,000.00	842,000.00
2107	Томилолт, зочны зардал	280,000.00	3,978,800.00
210702	Дотоод албан томилолт	280,000.00	3,978,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,599,050.00	44,575,606.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,449,038.00	43,293,566.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	420,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	267,842.00	173,140.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	65,000.00	88,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	233,822,662.16	214,908,607.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,766,334.00	62,486,180.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	183,396,328.16	152,422,427.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,323,578.84	97,556,320.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,888,058.00	34,625,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	29,625,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,888,058.00	5,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,435,520.84	62,930,820.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,435,520.84	62,930,820.36
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	263,226,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	263,226,400.00
221001	Их засвар	-	263,226,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(59,599,884.16)</u>	<u>27,185,398.38</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(59,599,884.16)</u>	<u>27,185,398.38</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	650,717,567.00	271,310,311.50	1,023,277,154.45	1,945,305,032.95
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	27,185,398.38	27,185,398.38
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	650,717,567.00	271,310,311.50	1,050,462,552.83	1,972,490,431.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>443,188,438.00</u>	<u>936,502,566.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,669,700.00	1,867,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,669,700.00	1,867,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,669,700.00	1,867,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,669,700.00	1,867,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,518,738.00	934,634,966.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,730,838.00	36,085,266.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,150,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,730,838.00	21,435,266.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	420,787,900.00	898,549,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	420,787,900.00	898,549,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	443,188,438.00	571,296,066.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	443,188,438.00	571,296,066.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,864,859.16	473,739,745.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,888,049.16	259,315,900.00
210101	Үндсэн цалин	254,888,049.16	259,315,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,088,200.00	36,769,801.64
210201	Тэтгэврийн даатгал	22,280,600.00	26,397,201.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,558,600.00	2,593,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,046,900.00	2,074,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	511,700.00	518,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,690,400.00	5,186,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,559,052.00	13,350,000.00
210301	Гэрэл, цахилгаан	4,224,305.00	5,700,000.00
210302	Түлш, халаалт	15,334,747.00	7,650,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,155,394.00	32,517,278.00
210401	Бичиг хэрэг	4,846,130.00	5,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,781,800.00	14,206,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	3,223,400.00
210404	Ном, хэвлэл	480,000.00	464,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,417,254.00	5,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,630,210.00	4,623,628.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	600,000.00
210604	Урсгал засвар	-	600,000.00
2107	Томилолт, зочны зардал	280,000.00	3,978,800.00
210702	Дотоод албан томилолт	280,000.00	3,978,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,599,050.00	45,025,606.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,449,038.00	43,743,566.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	420,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	267,842.00	173,140.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	65,000.00	88,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,795,114.00	82,182,360.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,135,114.00	82,182,360.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,323,578.84	97,556,320.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,888,058.00	34,625,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	29,625,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,888,058.00	5,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,435,520.84	62,930,820.36

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,435,520.84	62,930,820.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>365,206,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	365,206,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	365,206,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	365,206,500.00
221001	Их засвар	-	263,226,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	101,980,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(365,206,500.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	900,049,700.00	837,486,479.64	62,563,220.36	93.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	541,465,400.00	530,960,679.64	10,504,720.36	98.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	506,839,900.00	496,335,179.64	10,504,720.36	97.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,315,900.00	259,315,900.00	-	100.00
210101	Үндсэн цалин	259,315,900.00	259,315,900.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,007,600.00	36,769,801.64	1,237,798.36	96.74
210201	Тэтгэврийн даатгал	27,635,000.00	26,397,201.64	1,237,798.36	95.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,593,200.00	2,593,200.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,074,500.00	2,074,500.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	518,600.00	518,600.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,186,300.00	5,186,300.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,000,000.00	13,350,000.00	6,650,000.00	66.75
210301	Гэрэл, цахилгаан	5,700,000.00	5,700,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	14,300,000.00	7,650,000.00	6,650,000.00	53.50
2104	Хангамж, бараа материалын зардал	32,207,000.00	31,811,278.00	395,722.00	98.77
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	13,500,000.00	13,500,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,600,000.00	3,223,400.00	376,600.00	89.54
210404	Ном, хэвлэл	480,000.00	464,250.00	15,750.00	96.72
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,627,000.00	4,623,628.00	3,372.00	99.93
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	600,000.00	600,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	600,000.00	600,000.00	-	100.00
2107	Томилот, зочны зардал	3,978,800.00	3,978,800.00	-	100.00
210702	Дотоод албан томилот	3,978,800.00	3,978,800.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,945,000.00	92,977,040.00	967,960.00	98.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,695,000.00	91,695,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	600,000.00	600,000.00	50.00

210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	420,900.00	79,100.00	84.18
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	173,140.00	126,860.00	57.71
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	88,000.00	62,000.00	58.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,785,600.00	57,532,360.00	1,253,240.00	97.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,785,600.00	57,532,360.00	1,253,240.00	97.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,625,500.00	34,625,500.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,625,500.00	34,625,500.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,625,500.00	29,625,500.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	358,584,300.00	306,525,800.00	52,058,500.00	85.48
2200	Дотоод эх үүсвэрээр	358,584,300.00	306,525,800.00	52,058,500.00	85.48
221001	Их засвар	348,181,800.00	296,126,400.00	52,055,400.00	85.05
222001	Тоног төхөөрөмж	10,402,500.00	10,399,400.00	3,100.00	99.97
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	169,782,300.00	837,486,479.64	(667,704,179.64)	493.27
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	168,282,300.00	835,618,879.64	(667,336,579.64)	496.56
132001	Орон нутгийн төсвөөс	168,282,300.00	835,618,879.64	(667,336,579.64)	496.56
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.00	1,867,600.00	(367,600.00)	124.51
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	1,867,600.00	(367,600.00)	124.51
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,085,266.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,085,266.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,085,266.00
2104	Хангамж, бараа материалын зардал	706,000.00
210402	Тээвэр, шатахуун	706,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,729,266.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,729,266.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,650,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,650,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,085,266.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,085,266.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,150,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,435,266.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,500,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэнхэр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнхэр сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 8 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэнхэр сумын ЗДТГ нь Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр, Улсын Их Хурлаас гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, түүнтэй нийцүүлэн гаргасан нутгийн захиргааны шийдвэрүүдэд хяналт тавьж биелэлтийг хангуулахад байгууллагын зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнхэр сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 900.0 сая төгрөгөөс 1%-иар буюу 9.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 %-иар буюу буюу 6.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 24.7 сая төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна. Оны эхний үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс байхгүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
1	2	3	4=3-2	
Бараа материал	47.9	46.2	(1.7)	(3.7)
Үндсэн хөрөнгө	1,900.1	1,926.5	26.4	1.4
Нийт хөрөнгө	1,948.0	1,972.7	24.7	1.3
Өр төлбөр	2.8	-	(2.8)	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,945.2	1,972.7	27.5	1.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,948.0	1,972.7	24.7	1.3

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Бараа материал эхний үлдэгдлээс 1.7 сая төгрөг буюу 3.7 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 47.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 92.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 94.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 46.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 26.4 сая төгрөг буюу 1.4 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,900.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 101.9 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 79.1 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар, 14.2 сая төгрөгийн акталсан хөрөнгийг орлогод авч нийт 181.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурч 1,926.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой бөгөөд тайлант хугацаанд 24.7 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Код	Үзүүлэлт	/сая.төгрөг/		
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	553.34	1,016.44	463.10
2	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1.67	1.87	0.20
3	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	110.15	79.94	-30.21
4	Нэмэлт санхүүжилтийн орлого	20.73	36.09	15.35
5	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	420.79	898.55	477.76
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	612.94	726.03	113.09
7	Бараа, ажил үйлчилгээний зардал	592.61	628.47	35.86
8	Урсгал шилжүүлэг	20.32	97.56	77.23
9	Хөрөнгийн зардал		263.20	263.20
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-59.60</u>	<u>27.21</u>	86.81

Цэнхэр сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 463.1 сая төгрөг буюу 45.5 хувиар өссөн нь орон нутгаас авах санхүүгийн дэмжлэг нэмэгдэж хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 472.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 427.9 сая төгрөгөөр өсгөж нийт зардлыг 900.0 сая төгрөгөөр хянаж баталжээ. Энэ нь ИТХ-ын тэргүүлэгчдээс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 900.0 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 168., сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 730.3 сая төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.5 сая төгрөгийн санхүүжилт авч 837.5 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 62.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний бусад зардлаас 10.5 сая төгрөг, хөрөнгийн зардлаас 52.1 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 36.1 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

1. Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас 10.8 сая төгрөгийн санхүүжилт ирснийг сумын Засаг даргын захирамжаар ковид 19 цар тахлын тусгаарлах байрны хоол, хүнс, шатахуун, бусад зардалд зарцуулсан байна.
2. Аймгийн Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогод зориулж 1.4 сая төгрөг, Ар ус Ундарга ХХК-аас усны төлбөрт 7.7 сая төгрөг, аймгийн ГХБЗХГ-аас хүүхэд хамгааллын зардалд 0.2 сая төгрөг, аймгийн ЗДТГ-аас цэрэг хүргэлтийн шатахуунд 1.0 сая төгрөг, аймгийн ИТХ-аас санхүүгийн дэмжлэг 0.4 сая төгрөг нийт 10.7 сая төгрөгийн санхүүжилтийг сумын Засаг даргын захирамж шийдвэрийн дагуу зарцуулсан байна.
3. Сумын өвс тэжээлийн нөөцөөс 9.5 сая төгрөгийн өвс тэжээлийг малчдад худалдан борлуулж нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна..
4. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу иргэн, аж ахуйн нэгжүүдээс ковид 19 цар тахалтай холбоотой

5.1 сая төгрөгийн хандивын орлого төвлөрснийг сумын Засаг даргын 2021 оны захирамжийн дагуу тусгаарлах байрны хоол, хүнс, аж ахуйн материал болон шатахууны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант жилийн эхэнд Байгаль орчны улсын байцаагчид төрийн албанд ажилласан хугацааны тэтгэмжийг холбогдох нотлох баримтуудыг үндэслэж олгоогүй, төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 900.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 93.0 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд орон тоо нэмэгдүүлээгүй, шагнал урамшуулал олгоогүй, автомашин худалдан аваагүй байна.
2. Суудлын автомашин ашиглалтын хувьд: Тус байгууллага нь 2011-2019 онуудад үйлдвэрлэгдсэн 151.3 сая төгрөгийн төсөв бүхий 5 автомашин ашигладаг бөгөөд жилийн шатахууны зардалд 7.5 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардалд 3.0 сая төгрөгийг тус тус зарцуулж, үндсэн орон тооны 1, гэрээт 2 жолоочтой байна.
3. Ковид-19 цар тахалтай холбоотой иргэн ААНБ-аас 5.1 сая төгрөгийн мөнгөн, 4.3 сая төгрөгийн мөнгөн бус хандив хүлээн авч зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цэнхэр сумын ЗДТГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 144 мэдээллээс 141 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин 13 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант онд батлагдсан төсвийн 13.4 хувь буюу 62.6 сая төгрөгийн хэмнэлт бий болгож төсөвт буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэж байна.
2. "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам", Төрийн албаны тухай хуулийн 27.1, 27.2, 46.2.2, 46.3 заалтуудыг тус тус зөрчигдсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн 4.1.3 дахь заалт, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цэнхэр сумын ЗДТГ-д завсрын аудит хийгдээгүй байна.

3.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналт, үндсэн хөрөнгийн элэгдлийн хугацаатай холбоотой зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж биелэлтийг Цэнхэр сумын ЗДТГ-ын даргын 2021.06.04-ны 03/252 тоот албан бичгээр хангуулсан байна.

3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн жинхэнэ албан хаагчийн сул оронд хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулсан эсэхийг шалгах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 39.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 10.3 сая төгрөгийг залруулж, 29.6 сая төгрөгийн зөрчилд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илэрсэн алдаа зөрчил нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн нийцлийн аудитын батламж мэдэгдлийг хангаагүй тул материаллаг илрүүлэлт гэж үзэн “Хязгаарлалттай” дүгнэлт хүргүүлж байна.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад орлого үр дүнгийн тайлан 0.4 сая төгрөгөөр, Мөнгөн гүйлгээний тайлангийн биет бус хөрөнгө худалдан авсан зардал 9.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг санхүүгийн тайланд залрууллаа.

4.2 Албан шаардлага

Байгаль орчны улсын байцаагч Ж.Эрдэнэдалайд 36 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмж урамшуулал 29.6 сая төгрөгийг тэтгэвэрт тогтоолгоогүй байхад олгосон нь "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 5.3 дахь заалтыг зөрчсөн байна. Мөн дээрх сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах хүсэлтийг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлээгүй одоог хүртэл үргэлжлүүлэн ажиллуулж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 27.1, 27.2, 46.2.2, 46.3 заалтуудтай нийцэхгүй, Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цэнхэр сумын ЗДТГ-ын Байгаль орчны улсын байцаагчийн албан тушаалд сонгон шалгаруулалт явуулах саналыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, Төрийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Цэнхэр сумын ЗДТГ	1	10.3	1	10.3						
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Цэнхэр сумын ЗДТ	2	29.6					1	29.6	1	
НИЙТ ДҮН		3	39.9	1	10.3			1	29.6	1	